



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 10 сарын 12 өдөр

Дугаар 299

Улаанбаатар хот

Г “Монинжбар” ХК-ийн бүтээн байгуулалт Г
бондыг бүртгэлээс хасах тухай

Үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг хөрөнгө оруулагчдад бүрэн төлж барагдуулсан болохыг ТЭМДЭГЛЭН, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.7, Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай журам”-ын 8 дугаар бүлгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Монинжбар” ХК-ийн гаргасан нэг бүр нь 10000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 120000 ширхэг бондыг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар/С.Тулгаа/, Хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК/Х.Алтай/, Үнэт цаасны хадгаламжийн бүртгэлээс хасахыг “ҮЦТТТХТ” ХХК/Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /С.Тулгаа/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газарт тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН